



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД
ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025.08.18 № 05/14247
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн гадаад, дотоод сүлжээ, сервер, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан Засгийн газрын ахлах референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дашийн Баясгалан, Захиргаа, зохион байгуулалтын газрын даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Норжинлхамын Мөнхбат, мөн газрын Хэрэг эрхлэх газрын хүний нөөц /сургалт, шагнал, цалин хөлс, зэрэг дэв, нийгмийн баталгаа/-ийн асуудал хариуцсан Засгийн газрын ахлах референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганбаатарын Нарангуа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Н.ДАМДИНСҮРЭН



142503015031

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар

Бичиг хэрэг

Огноо 2015.08.20

10

30.

цаг минут